

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	3
2. Аудитын тайлан .....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	8
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	8
2.8. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн .....	8
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	12
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	14
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	15
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	15
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	15
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	15
3. Менежментийн захидал .....	15
3.1 Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сантай холбоотой асуудал .....	16
3.2 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал .....	17
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	18
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	18
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	19
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	20
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	21
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	22
4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	24
5.Хавсралт.....	25
5.1Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	25
5.2 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар тогтоосон төлбөрийн актын нэгтгэл.....	27
5.3 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар тавьсан албан шаардлагын нэгтгэл.....	28
5.4 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	29

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
	Эрүүл мэндийн даатгалын сан



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2020.04.24 № 1321  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД БӨГӨӨД  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  
Д.САРАНГЭРЭЛ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2019 оны төсвийн гүйцэтгэл, нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Аудитын гол асуудал

- Арилжааны банканд байршиж байгаа 53,917.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгөд эрсдэл үүссэн;
- Төр төлбөрийг нь хариуцах иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын 26,501.2 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Тайлант оны орлогоос 31,801.8 сая төгрөгийн эрсдэлийн санг үүсгээгүй
- зэрэг нь оршин байх, эрх ба үүрэг, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Үүрэг хариуцлага

Сангийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Д.ЗАНДАНБАТ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Эрүүл мэндийн сайд бөгөөд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга Д.Сарангэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг байгуулах, мөнгөн хөрөнгийг эрсдэлгүй удирдах, авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулах, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 06-аас 2020 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор П.Чанцалдулам, аудитор Л.Мөнхцацрал нар гүйцэтгэв.

Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А-1/348 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

## **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Эрүүл мэндийн даатгалын сангийн эрхэм зорилгыг “Монгол хүн бүрийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, даатгалын тогтвортой санг бүрдүүлэн, даатгуулагчийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг худалдан авдаг үйлчлүүлэгч төвтэй, нийгмийн хариуцлага бүхий менежментийг хэрэгжүүлэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14<sup>1</sup>.1-д “ Эрүүл мэндийн даатгалын удирдах дээд байгууллага нь Үндэсний зөвлөл байна” гэж заасны дагуу хуулиар хүлээсэн эрх, үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар сарын 15-ны 78 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даргаар Эрүүл мэндийн сайд томилогдон ажиллаж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг бүрдүүлж, даатгуулагчийн өмнөөс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар эрхэлж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл нь:

1. Даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээ худалдан авдаг, хэрэглэгч, үйлчлүүлэгч төвтэй, нийгмийн хариуцлага бүхий эрүүл мэндийн даатгалын бие даасан тогтолцоог бүрдүүлэх;
2. Байгууллагын дотоод, гадаад харилцааг өргөжүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалан даатгуулагч төвтэй, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх;
3. ЭМДЕГ нь даатгуулагчдад нээлттэй, ил тод, хариуцлагатай байдлыг хангаж сайн засаглалын зарчмыг баримталж, даатгуулагчийн эрхийг дээдэлсэн, тэдний эрүүл мэндийн хэрэгцээнд нийцсэн, чанартай, үр дүнтэй, аюулгүй тусламж, үйлчилгээг үзүүлж, болзошгүй санхүүгийн эрсдэлээс хамгаалах;
4. Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаа нь нотолгоонд тулгуурласан, нийгмийн түншлэл, зөвшилцлийг хангахуйц байнгын тасралтгүй байх;
5. ЭМДЕГ болон салбар нэгжүүдтэй холбогдсон мэдээллийн нэгдсэн цахим сүлжээ, мэдээллийн цахим сан бүрдүүлэх.

Стратегийн зорилт:

1. Даатгалын хамралтыг нэмэгдүүлэн сангийн тогтвортой байдлыг бүрдүүлэх, шимтгэл төлөлтийг идэвхжүүлэх, ялангуяа албан бус сектор, ажилгүй иргэд рүү хандсан үйл ажиллагааг сайжруулах;
2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчийн даатгалын санхүүжилтийн төсөв, нэхэмжлэл шалгах үйл ажиллагааг сайжруулан зардлыг хянах, үр ашгийг нэмэгдүүлэх;
3. Даатгалын тусламж, үйлчилгээний багцыг үр дүнтэй удирдаж, сангийн орлого, зарлагын тэнцвэрийг хадгалах, сангийн зардлын хэтийн тооцоонд актуар тооцоолол, шинжилгээ хийж, шимтгэлийн хувь, хэмжээг зохистой түвшинд тогтоох талаар бодлогын хувилбаруудыг боловсруулж, холбогдох байгууллагад санал хүргүүлэх;
4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртгийн судалгаанд үндэслэн тусламж, үйлчилгээний өртөг тооцох нэгдсэн аргачлалыг боловсруулж хэрэгжүүлэх замаар бодит тарифыг бий болгох;

5. Эрүүл мэндийн даатгалын болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай холбогдсон мэдээллийн технологийн дэд бүтцийг бий болгон, хөгжүүлэх, даатгуулагчийн эрүүл мэндийн мэдээллийг цахим болгох;
6. Тусламж, үйлчилгээний хяналт үнэлгээний үйл ажиллагааны хүрээг өргөжүүлж, чанарын шалгуур үзүүлэлтийг сайжруулах, тусламж, үйлчилгээний чанарын хяналт, үнэлгээг цахим мэдээ, мэдээлэлд суурилан нэгдсэн журмаар хэрэгжүүлдэг тогтолцоог бий болгох болон бусад.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЭМДҮЗ-ийн 2019 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн 07 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтцийг шинэчлэн баталсан;
- Эрүүл мэндийн даатгалын сангийн салбарт мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулсан;
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”;
- Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар батлагдсан “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”;
- Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”;
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар батлагдсан “Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ыг 1 дүгээр, “Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд”-ийг 2 дугаар, “Автомашинны шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж, жишээ”-г 3 дугаар, “Автомашинны эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн норм”-ыг 4 дүгээр, “Автомашинны сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаарын норм”-ыг 5 дугаар хавсралтаар баталсан;
- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөн тогтоосон байна.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэн боловсруулагдсан боловч салбарын зарим онцлогийг тусгаагүйгээс зарим цикл дотоод хяналт хэрэгжихгүй байх үр дагавартай байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

Эрүүл мэндийн яам болон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дотоод аудитын нэгж 2019 онд Эрүүл мэндийн даатгалын сангийн харьяа салбаруудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, эрсдэлийн удирдлагаар хангаж ажиллаагүй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын дүнг сонгов. Суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгосон нь тухайн жилийн бодит зардлыг илэрхийлдэгтэй холбоотой юм.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 358,373.1 сая төгрөгийн 1 хувь буюу 3,583.7 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

## 2.8 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

### 2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 574,974.5 сая, эцсийн үлдэгдэл 557,520.3 сая төгрөг болж, 17,454.2 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө			
Банканд байгаа бэлэн мөнгө	158,974.5	324,520.3	165,545.8
Замд яваа мөнгөн хөрөнгө			
Хадгаламж	416,000.0	233,000.0	(183,000.0)
<b>Дүн</b>	<b>574,974.5</b>	<b>557,520.3</b>	<b>(17,454.2)</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	639.5	0	(639.5)
Төсөл/ сан	574,335.0	557,520.3	(16,814.7)
ТӨҮГ болон ОНӨҮГ			
<b>Дүн</b>	<b>574,974.5</b>	<b>557,520.3</b>	<b>(17,454.2)</b>

*Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Банканд байршиж буй 557,520.3 сая төгрөгийн 324,520.3 сая төгрөг нь харилцах дансанд, 233,000.0 сая төгрөг нь Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн үлдэгдлээс арилжааны банканд байршуулсан хадгаламж байна.

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг зарцуулах, банканд хадгалах, Засгийн газрын бонд, Монгол банкны үнэт цаас худалдан авах журмын дагуу Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 04-ний 2 дугаар тогтоолоор 46,000.0 сая төгрөг, 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 08 дугаар тогтоолоор 150,000.0 сая төгрөг, 2019 оны 07 дугаар сарын 05-ны 10 дугаар тогтоолоор 68,000.0 сая төгрөгийг тус тус арилжааны банканд хадгаламжийн хэлбэрээр байршуулж, богино хугацаат 31,000.0 сая төгрөгийн хадгаламжийг харилцах дансанд эргүүлэн татсан



байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Нэр бүхий 2 арилжааны банкны харилцах дансанд байрших Эрүүл мэндийн даатгалын сангийн 53,917.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгөд эрсдэл үүссэн байна. Тайлант онд Монгол банкнаас хянасан зохист харьцааны үзүүлэлтээ ирүүлээгүй, 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар алдагдалтай, өөрийн хөрөнгийн хэмжээ сөрөг дүнтэй, эрсдэлийн сан нь үлдэгдэлгүй байгаагаас гадна төлбөр гүйцэтгэх чадвар буурснаас оны сүүлд өгсөн 8,000.0 сая төгрөгийн төлбөрийн даалгавар биелүүлээгүй;
- ЭМДҮЗ-ийн 2018 оны "Хөрөнгийн зохист харьцаа тогтоох тухай" 14 дүгээр тогтоолоор баталсан харилцах дансанд байвал зохих хөрөнгийн хэмжээг баримтлаагүйн улмаас харилцах дансны жилийн эцсийн үлдэгдэл өмнөх оныхоос 166,185.3 сая төгрөгөөр өсөж, хадгаламжийн хэмжээ 183,000.0 сая төгрөгөөр буурчээ. Тайлант онд 7,577.9 сая төгрөгийн хүүгийн орлого олох боломжийг алдсан;

## 2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 18,414.4 сая, эцсийн үлдэгдэл 180,157.1 сая төгрөг болж, 161,742.7 сая төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага			
Төлбөртэй үйлчилгээний авлага	1.6	0	(1.6)
Татаас, санхүүжилтийн авлага	6,840.0	26,495.3	19,655.3
Зээлийн хүүгийн авлага			
Дансны авлага /ТӨҮГ/			
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/			
Бусад авлага	11,572.8	153,661.8	142,088.9
Зээлийн авлага			
<b>Дүн</b>	<b>18,414.4</b>	<b>180,157.1</b>	<b>161,742.7</b>
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	126.7	34.5	(92.2)
Төсөл/ сан	18,287.7	180,122.6	161,834.9
ТӨҮГ болон ОНӨҮГ			
<b>Дүн</b>	<b>18,414.4</b>	<b>180,157.1</b>	<b>161,742.7</b>

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Монгол банкны эрх хүлээн авагч татан буугдсан Капитал банканд байршиж байсан мөнгөн хөрөнгийн нэхэмжлэлийг 2019 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр 136,113.2 сая төгрөгөөр баталгаажуулж, Банкны тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.8 дахь хэсэгт заасан төлбөр барагдуулах дараалалд бүртгэснийг авлага дансанд бүртгэсэн нь нийт дансны үлдэгдлийн 75.0 хувийг эзэлж байна.

Төр төлбөрийг нь хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн /Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас авах/ 26,490.3 сая төгрөгийн авлага, хугацааны эцэст хүүг төлөх нөхцөлтэй хадгаламжийн хүүгийн авлага 7,571.0 сая төгрөг, Нийгмийн даатгалын санд төвлөрч, оны эцэст шилжүүлж амжаагүй эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн авлага 7,776.3 сая төгрөг, бусад авлагын 2,206.3 сая төгрөг бүртгэгдсэний насжилт 1-2 жил байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Эрүүл мэндийн даатгалын сан нь Хөдөлмөр, нийгэм, хамгааллын яамнаас авах төр төлбөрийг нь хариуцах иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын 26,501.2 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй

## 2.8.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 578.8 сая, эцсийн үлдэгдэл 706.0 сая төгрөг болж, 127.2

сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	578.8	706.0	127.2
Томилолтын урьдчилгаа			
<b>Дүн</b>	<b>578.8</b>	<b>706.0</b>	<b>127.2</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага		207.5	207.5
Төсөл/ сан	578.8	498.5	(80.3)
ТӨҮГ болон ОНӨҮГ			
<b>Дүн</b>	<b>578.8</b>	<b>706.0</b>	<b>127.2</b>

*Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урьдчилгаа дансны үлдэгдлийн 444.1 сая төгрөг нь Нийгмийн даатгалын сангийн балансаас балансад бүртгэсэн 2012 оны урьдчилж гарсан зардал, 264.9 сая төгрөг нь тайлант онд үүссэн Эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилт болон бусад зардлын урьдчилгаа байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас “Эрүүл хүүхэд, эрүүл шүд аян”-ы хүрээнд 2012 онд урьдчилж олгосон 444.1 сая төгрөг нь нийт дансны үлдэгдлийн 62 хувийг эзлэх бөгөөд өмнөх аудитаар уг зардлын хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг үнэлж, данс бүртгэлд тусгах талаар албан шаардлага өгсний дагуу 2019 оны 3 дугаар сарын 07-ны өдөр Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга А/41 тушаалаар ажлын хэсэг байгуулж, хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна.

*Аудитын илрүүлэлт:*

- Эрүүл мэндийн даатгалын сан нь Хөдөлмөр, нийгэм, хамгааллын яамнаас авах төр төлбөрийг нь хариуцах иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын 26,501.2 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

## 2.8.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 47.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 59.3 сая төгрөг болж, 11.7 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>			
<b>Хангамжийн материал</b>	<b>47.6</b>	<b>59.3</b>	<b>11.7</b>
Бичиг хэргийн материал	5.8	7.1	1.3
Аж ахуйн материал	13.8	7.3	(6.5)
Сэлбэг, хэрэгсэл	2.7	9.5	6.8
Түлш, шатах тослох материал	5.1	3.8	(1.3)
Бусад хангамжийн материал	20.2	31.6	11.4
<b>Дүн</b>	<b>47.6</b>	<b>59.3</b>	<b>11.7</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	47.6	59.3	11.7
Төсөл/ сан			
<b>Дүн</b>	<b>47.6</b>	<b>59.3</b>	<b>11.7</b>

*Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын дансны үлдэгдлийн өсөлтөд бусад хангамжийн материалын үлдэгдэл 11.7 сая төгрөгөөр өссөн нь голлох нөлөө үзүүлсэн бөгөөд тайлант онд 24 салбарт зориулж гадна хаяг 3.6 сая төгрөг, хулдаасан хэвлэл 3.1 сая төгрөгөөр бэлтгэсэн, бусад хангамжийн материал 5.0 сая төгрөгөөр нэмж бэлтгэснээс үүдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд байгууллагын үйл ажиллагаанд ашиглах боломжгүй 2.3 сая төгрөгийн бараа материал байгааг өмч хамгаалах комисс албажуулж, данс бүртгэлээс хасаагүй байна.

*Аудитын илрүүлэлт:*

- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь 2.3 сая төгрөгийн бараа материалыг ашиглалтгүй болсныг өмч хамгаалах комисс албажуулж, данс бүртгэлээс хасаагүй.

### 2.8.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,890.8 сая, эцсийн үлдэгдэл 3,674.6 сая төгрөг болж, 783.8 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Газар	13.8	13.8	
Биет хөрөнгө	2,448.8	2,718.4	269.6
Биет бус хөрөнгө	428.2	942.4	514.2
<b>Дүн</b>	<b>2,890.8</b>	<b>3,674.6</b>	<b>783.8</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	2,890.8	3,674.6	783.8
Төсөл/ сан			
<b>Дүн</b>	<b>2,890.8</b>	<b>3,674.6</b>	<b>783.8</b>

*Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд үндсэн хөрөнгийн данс нь нэмж бэлтгэсэн 898.3 сая төгрөг, балансаас баланст шилжүүлэн авсан 193.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, элэгдлийн зардал 308.2 сая төгрөгөөр буурсан байна.

*Аудитын илрүүлэлт:*

- Өмнөх онд үнэлгээ хийсэн 13.8 сая төгрөгийн газрын эзэмших гэрчилгээний маргаантай асуудлыг шийдвэрлээгүй байна.

### 2.8.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 4,639.7 сая, эцсийн үлдэгдэл 2,671.9 сая төгрөг болж, 1,967.8 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	4,639.7	2,671.9	(1,967.8)
Татаас, санхүүжилтийн өглөг	2,546.6	2,546.6	
Байгууллагад төлөг өглөг	2,085.4	118.8	(1,966.6)
Урьдчилж орсон орлого	7.7	6.5	(1.2)
<i>Урт хугацаат өр төлбөр дүн</i>			
<b>Нийт дүн</b>	<b>4,637.7</b>	<b>2,671.9</b>	<b>(1,967.8)</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	14.9	14.6	(0.3)
Төсөл, сан	4,624.8	2,657.3	(1,967.5)
<b>ДҮН</b>	<b>4,637.7</b>	<b>2,671.9</b>	<b>(1,967.8)</b>

*Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны төр хариуцах иргэдийн санхүүжилттэй холбоотой 2,546.6 сая төгрөгийн өглөг, Эрүүл хүүхэд, эрүүл шүд аяны хүрээнд бий болсон 55.4 сая төгрөгийн өглөг, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний болон бусад зардлын 69.9 сая төгрөгийн өглөг бүртгэлтэй байна.

*Аудитын илрүүлэлт:*

- Эрүүл мэндийн даатгалын сан нь Төр шимтгэлийг нь хариуцах ирээдтэй холбоотой урд онд үүссэн 2,546.6 сая төгрөгийн өглөгийг барагдуулах арга хэмжээ аваагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь 2018 онд Нийгмийн даатгалын сангаас балансаас балансад шилжиж ирсэн 14.1 сая төгрөгийн өглөгийг барагдуулах арга хэмжээ аваагүй;
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь 14.6 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй

## 2.8.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 592,266.4 сая, эцсийн үлдэгдэл 739,445.5 сая төгрөг болж, 147,179.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Засгийн газрын хувь, оролцоо дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал	13.8	13.8	
Хуримлагдсан үр дүн	592,252.6	739,431.7	147,179.1
<b>Дүн</b>	<b>592,266.4</b>	<b>739,445.5</b>	<b>147,179.1</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	3,689.6	3,961.3	271.7
Төсөл, сан	588,576.8	735,484.2	146,907.4
Төрийн сан			
ТӨҮГ болон ОНӨҮГ			
<b>Дүн</b>	<b>592,266.4</b>	<b>739,445.5</b>	<b>147,179.1</b>

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо данс нь тайлант оны үр дүн 146,417.2 сая төгрөг, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт 761.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, оны эцэст 739,445.5 сая төгрөг болсон байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөд хугацааны эцэст хүүг төлөх нөхцөлтэй хадгаламжийн өмнөх оны үр дүнд хамаарах хүүгийн орлого 761.9 сая төгрөгийг бүртгэсэн байна.

## 2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсөв захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 407,667.3 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 469,617.8 сая төгрөг төвлөрч, батлагдсан төсвөөс 61,950.5 сая төгрөгөөр давсан нь Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 24 дүгээр “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолоор цалин нэмэгдсэн, Хөдөлмөр, нийгмийн гурван талт үндэсний хорооны 2018 оны 05 дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 320,000.00 төгрөг байхаар шинэчлэн тогтоосонтой холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 350,958.0 сая төгрөг буюу 86.1 хувьтай, 56,709.6 сая төгрөг дутуу зарцуулжээ.

Эрүүл мэндийн даатгалын сангаас төрийн болон хувийн хэвшлийн Эрүүл мэндийн байгууллагуудад олгосон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлыг 350,799.5 сая

төгрөг төсөвлөж, гүйцэтгэлээр 305,951.9 сая төгрөг зарцуулж, 44,847.6 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна. 2018-2019 онд тусламж, үйлчилгээний 10-н төрөлд нийт 12 удаа сонгон шалгаруулалт зохион байгуулж, тайланд онд 1977 байгууллагатай гэрээ байгуулан ажилласан байна.

Батлагдсан төсвөөс материаллаг дүнтэй, дутуу зарцуулсан дараах зардлууд байна. Үүнд:

Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үзүүлэх 4 төрлийн тусламж үйлчилгээний зардал 3,736.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь эдгээр төвүүдийн хүний нөөц, тоног төхөөрөмжийн хангамжтай холбоотой, Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний зардал 3,168.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь нийт 221 төвөөс 136 нь сонгон шалгаруулалтад орж гэрээ байгуулж, төлөвлөснөөс 85 өрхийн эрүүл мэндийн төвд санхүүжилт олгоогүй;

Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн элэгний В, С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээг хийж буй нийслэлийн 24 лабораторийг шалгасан ажлын хэсгийн удирдамжаар 15 лабораторийн даатгалын гэрээг түр зогсоож, санхүүжилт олгоогүйгээс 4,220.4 сая төгрөгийн зардал дутуу зарцуулагдсан;

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг оношилгоо шинжилгээнд хамрагдах иргэдийн идэвх, санаачилгатай холбоотойгоор 6,197.7 сая төгрөгийн зардал, В, С вирусийг илрүүлэх, баталгаажуулах шинжилгээний оношлуурын төхөөрөмжийг худалдан авах ажиллагааны зохион байгуулалттай холбоотойгоор 3,002.4 сая төгрөгийн зардал, Магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн спортоор хичээллэх үйлчилгээний магадлан итгэмжлэх ажлын зохион байгуулалтаас хамаарч 2,000.0 сая төгрөгийн зардал тус тус зарцуулагдаагүй;

Төрийн болон хувийн эмийн сангуудад олгох хөнгөлөлттэй эмийн зардал 51,544.3 сая төгрөгөөр төсөвлөж, гүйцэтгэлээр 40,549.2 сая төгрөг зарцуулж 10,995.1 сая төгрөг хэмнэгдсэн байна. Энэ нь элэгний В, С вирусийн жор бичих эрх бүхий эмч нарыг хурууны хээгээр бүртгэж баталгаажуулдаг болсон, 2017 оноос хойш “Элэг бүтэн монгол” хөтөлбөр тус тус идэвхтэй хэрэгжиж С вирусийн өвчлөл буурч, С вирусийн эсрэг эмийн хэрэглээ багассантай холбоотой байна.

**Нэмэлт төсөв:** Тайлант онд Эрүүл мэндийн яамны төсөвт төлөвлөгдсөн Эрүүл хүүхэд, эрүүл шүд аян, Гемодиализын үйлчилгээний зардлын санхүүжилтийн 9,640.7 сая төгрөг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 91.0 сая төгрөг, туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2.2 сая төгрөг, урд оны гемодиализын санхүүжилтийн авлага 124.2 сая төгрөг нийт 9,851.1 сая төгрөгийн орлогыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын нэмэлт санхүүжилтийн дансанд бүртгэсэн байна.

Нэмэлт санхүүжилтээс Эрүүл хүүхэд, эрүүл шүд аяны зардалд 9,496.8 сая төгрөг, бараа үйлчилгээний зардалд 173.7 сая төгрөг зарцуулж, 180.6 сая төгрөгийн үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэн байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь ХАА-ны төлөвлөгөөнд тусгаагдаагүй 329.0 сая төгрөгийн программ хөгжүүлэх ажлыг хувь хүнтэй шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн;
- Эрүүл мэндийн даатгалын сан нь 16.4 сая төгрөгийн хүүгийн орлогыг дутуу тооцож, данс бүртгэлд тусгасан;
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь зардлын ангилал зөрчиж бүлэг хооронд гүйлгэн 11.5 сая төгрөг, анхан шатны болон үндэслэх баримт бүрдэл дутуу 15.5 сая төгрөгийн зардал тус тус бүртгэсэн. Төсвийн зориулалтыг зөрчиж ЭМДҮЗ-ийн хурлын зардалд 0.5 сая төгрөг зарцуулсан;
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь албан ажлын тээврийн хэрэгсэл унах эрхгүй албан тушаалтан болон балансад бүртгэлгүй автомашинд 1.6 сая төгрөгийн шатахууны талон олгож, зарцуулсан;

- *Томилолтын зардлын тооцооноос 1.8 сая төгрөгийн шатахууны болон анхан шатны баримт дутуу;*
- *Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь эдийн засгийн ангилал зөрчиж 1.2 сая төгрөгийн зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна.*

## **2.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэн үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 25 салбар нэгжийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг 2 төсвийн байгууллага, 1 тусгай сан нийт 3 санхүүгийн тайлан нэгтгэгдэж, аудитад хамрагдсанаас “Зөрчилгүй” 1, “Хязгаарлалтай” 2 дүгнэлт өгсөн.

Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 265,053.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 142,223.8 сая төгрөгийн алдааг залруулж, 21.3 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 54,263.1 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 68,545.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд 17 зөвлөмж өглөө.

### *Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага*

Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар дараах асуудалд албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитын албанаас аудит хийгдээгүй.
2. Эрүүл мэндийн үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 91,028.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн.
3. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны ажилчдаас дотоод хяналт, санхүүтэй холбоотой гомдол санал ирүүлсэн, дотоод аудитор 2 ажилтан томилогдсон боловч үүргээ хэрэгжүүлээгүй зэрэг нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасанд нийцэхгүй бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж, эрсдэлийн удирдлагаар хангаж ажиллаагүй байна.

### *Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар*

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа нь орон нутгийн 22 тасаг, 2 дүүрэг, Эрүүл мэндийн ерөнхий газар нийт 25 салбарын хэмжээнд зохион байгуулагддаг боловч орон тооны хүрэлцээгүй байдлаас үүдэж санхүүгийн тайланг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар толилуулж, төсвийн шууд захирагчийн аудитын цаглабарт хугацаанд аудитад хамрагдсан.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн санхүүгийн тайланд аудит хийж “Зөрчилгүй”, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын санхүүгийн тайланд “Хязгаарлалтай” дүгнэлт тус тус өглөө.

Аудитаар нийт 1,927.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,458.6 сая төгрөгийн алдааг залруулж, 4.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 345.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 117.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өглөө.

### *Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар*

Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүгийн тайланд аудит хийж “Хязгаарлалтай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 231,324.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 140,765.2 сая төгрөгийн алдааг залруулж, 16.4 сая төгрөгийн зөрчилд акт тогтоож, 53,917.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 36,625.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

#### **2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Монгол банк нь Капитал банканд байршиж байсан 136,113.2 сая төгрөгийн нэхэмжлэлийн төлбөр төлөх дарааллыг Банкны тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.8-д “Засгийн газарт төлөх өр, төлбөр, албан татвар” гэж тогтоосон байна. Тус банкны эд хөрөнгө, үл хөдлөх хөрөнгөөр хохирол барагдуулах ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шийдвэрлэлтийн явцыг дараагийн аудитаар авч үзнэ.

#### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 82 мэдээллийг хугацаанд нь, 58 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт, төсөв, гүйцэтгэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээ гэх мэт мэдээллүүдийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

#### **2.13. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 641.3 сая төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 1,543.9 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах 5 албан шаардлага хүргүүлж, 139,305.5 сая төгрөгийн алдааг засах, давтан гаргахгүй байх 17 зөвлөмж өгсний хэрэгжилтийг үнэлэхэд акт 100.0 хувь, албан шаардлага 76.7 хувь, зөвлөмж 88.3 хувийн биелэлттэй байна.

#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хязгаарлалттай дүгнэлт

Залруулагдаагүй 122,829.8 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 3,583.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлтийг өгч байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3. Менежментийн захидал**

---

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд Менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд

санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

